


### Хувьцааны мэдээлэл

Ханш /2025.01.27/	1285₮
Target price	1353.08₮
Тикер	MSE:GLMT
52 долоо хоног	846.88-1287₮
Зах зээлийн үнэлгээ	1.039 их наяд ₮
Нийт хувьцааны тоо	808,657,306
EPS	502.9
P/B	0.82
P/E	2.56

### Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



### Ханшийн хөдөлгөөн /2024.01-2025.01/



## “Голомт Банк” ХК

BUY

Target price/2025.12.31/: 1353.08₮

### Компанийн тухай

“Голомт банк” нь 1995 оны 3-р сарын 6-ний өдөр үүсгэн байгуулагдсан Монгол улсын томоохон банк санхүүгийн салбарын төлөөлөл бөгөөд одоогоор 1.6 сая гаруй харилцагч 140 гаруй салбар болон тооцооны төвтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

2024 оны онцлох үйл явдлууд:

- Олон улсын санхүүгийн корпораци (IFC) Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD)-тай хамтран 250 сая.ам долларын санхүүжилт татсан.
- Apple pay төлбөр тооцоо хийдэг болсон
- 2024 онд Голомт банк тогтвортой хөгжлийн зорилтыг дэмжин, олон улсын зах зээлд Ногоон бонд амжилттай гаргасан. Энэхүү санхүүжилт нь сэргээгдэх эрчим хүч, эко төслүүдэд зарцуулагдсан. Ногоон санхүүжилтийн хүрээнд нийт 50 гаруй төсөл санхүүжүүлсэн.

### Системийн 5 банкны төлөв байдал


Голомт банк 3%-ийн ROA-тай байгаа нь дундаас (2.4%) арай өндөр бөгөөд системийн бусад банкнуудтай харьцуулахад тогтвортой өсөлттэй байна. ROE 36.7%-тай байгаа нь дунджаас (24.3%) болон системийн бусад банкнуудаас илүү өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь өөрийн хөрөнгийн ашиглалтын үр ашиг өндөр байгааг илэрхийлж байна. Банкны салбарын нийт активын хэмжээ 71.4 их наяд байгаагаас Голомт Банк 21.5 хувийг дангаараа эзэлж байна.

	ROA	ROE	P/B	Нийт хөрөнгө*	Цэвэр ашиг*
Khan	3.2%	26.3%	0.9	20,302.7	638.5
TDB	2.0%	20.3%	0.9	15,016.0	300.1
<b>GLMT</b>	<b>3%</b>	<b>36.7%</b>	<b>0.8</b>	<b>15,410.2</b>	<b>406.7</b>
SBM	1.7%	17.1%	0.6	6,218.5	108.0
ХАС	2.7%	25.6%	1.2	6,317.7	170.8
Дундаж	2.4%	24.3%	0.9	12,653.0	324.94


\*тэрбум ₮

## САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

### ROA, ROE



### Ашгийн үзүүлэлтүүд /тэрбум ₮, хувиар/



### Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүд



2020 2021 2022 2023 2024

Зээл хадгаламжийн харьцаа	59.9%	61.1%	64.2%	59%	84.6%
Чанаргүй зээлийн хувь	8.5%	8.0%	7.3%	5.3%	3.1%

## АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /ROA, ROE/

2024 онд нийт хөрөнгийн өгөөж 3%-д хүрсэн нь санхүүгийн өгөөжийн хамгийн өндөр үзүүлэлт болж, банкны нийт хөрөнгийн менежмент болон үр ашгийн үзүүлэлт хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Өөрийн хөрөнгийн өгөөж нь 36.7%-тай гарч мөн оны өмнөх үеэс 16.5%-иар өссөн үзүүлэлт гарсан байна. Эдгээр өсөлт нь банкны хөрөнгө ашиглах сайжирч, бизнесийн стратеги нь үр дүнтэй байгааг харуулж байна.

### Цэвэр ашгийн маржин

2024 онд цэвэр ашиг өсөж (57.8%) цэвэр ашгийн маржин 31.3%-д хүрсэн нь банкны стратегийн оновчтой шийдвэрүүд болон бизнесийн тогтвортой өсөлтийн үр дүнг харуулж байна. 2024 онд Голомт банк гадны хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлж мөн зээлжих зэрэглэл өсөлт үзүүлэн орлогын эх үүсвэрүүдээ төрөлжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн нь орлогын өсөлтөд чухал нөлөө үзүүлсэн. Нийт цэвэр ашиг 406.7 тэрбум хүрч, өмнөх оны мөн үеэс 125 хувиар өссөн байна.

### Хүүгийн орлогын маржин

2024 оны эцсийн байдлаар тус үзүүлэлт нь 3.9 хувь болж өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна.

### Үндсэн үйл ажиллагаа

2024 оны эцсийн байдлаар нийт цэвэр зээл 7.2 их наяд хүрч, өмнөх оны мөн үеэс 57.8% өссөн бөгөөд нийт хөрөнгийн 63% эзэлж байна. Хадгаламжийн хувь өмнөх оных мөн үеэс 29.9%-иар өссөн байна. Чанаргүй активын хэмжээ сүүлийн 5 жилд хамгийн бага түвшинд буюу 3.1% байгаа нь зээлийн чанар, санхүүгийн эрсдэл удирдлагын тогтвортой байдал сайн түвшинд байгааг харуулж байна.

### Зээл хадгаламжийн харьцаа

Олон улсын жишгээр зээл хадгаламжийн харьцаа 70-80% орчимд байх нь сайн үзүүлэлт гэж тооцогддог. 2024 онд Голомт банк зээл хадгаламжийн харьцаа 84.6% байгаа нь хэвийн сайн үзүүлэлт юм.

### Дүгнэлт

“Голомт Банк” ХК нь Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, ТОП-20 индексийн бүрэлдэхүүнд багтдаг, хамгийн өндөр үнэлгээтэй компаниудын нэг бөгөөд нийт үнэлгээ нь 1 их наяд төгрөг байна. 2024 оны эцсийн байдлаар тус компанийн P/B харьцаа 1-ээс бага буюу 0.82 байгаа нь хувьцааны ханш зах зээл дээр бодит үнээс бага үнэлэгдэж, ашиг өндөр байгаа ч хувьцааны ханш хямд байгааг илтгэж байна. P/E харьцаа 10-аас бага буюу 2.56 байна. 2024 онд Голомт Банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр 2024 оны 2 сарын 14 өдөр 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг хувьцаа эзэмшигч нарт олгосон юм.